МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.28 № 65

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД Ц.ИДЭРБАТ ТАНАА

Монгол Улсын газар тариалангийн салбарын хөгжил, түүний нэмүү өртгийн сүлжээний талаар

Монгол Улсын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа газар тариалангийн салбар чухал үүрэгтэй. Тус салбар нь хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, хүнсний хангамж, аюулгүй байдлыг баталгаажуулахын зэрэгцээ ажлын байр, өрхийн орлогыг бий болгох, үйлдвэрлэл, боловсруулах салбарын түүхий эдийн хангамжийг бүрдүүлэх, импортыг орлох болон экспортын боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр 11.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд газар тариалангийн салбарын бодлого, хэрэгжилт, газар ашиглалт, төрийн дэмжлэг болон түүний үр дүнгийн талаар дараах асуултыг тавьж байна.

1.Монгол Улсын хэмжээнд газар тариалангийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа нийт газрын хэмжээ /кадастрын зураглалаар/, үүнээс бодитоор тариалалт хийж байгаа болон ашиглагдахгүй байгаа талбайн хэмжээг аймаг, сум, зориулалт, эзэмшил, ашиглалтын төрлөөр гаргаж, сүүлийн 10 жилийн өөрчлөлтийн мэдээлэл;

2."Атрын аян" болон газар тариалангийн салбарыг хөгжүүлэх төрийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд газар олголт, ашиглалт, тариалалтын талбай, ургац, ургацын хэмжээ, нэгж талбайн ургацын гарц, хүнсний дотоодын хэрэгцээний хангалтад гарсан өөрчлөлтийг зорилтот үзүүлэлттэй нь харьцуулсан байдлаар;

3.Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс сүүлийн 10 жилд олгосон мөнгөн урамшуулал, хөнгөлөлттэй зээл, үр, бордоо, шатахуун, техник тоног төхөөрөмж болон бусад дэмжлэгийн хэмжээ, хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо, дэмжлэгийн төрөл тус бүрийн зарцуулалт болон түүний үр дүнгийн талаар;

4.Төрөөс үзүүлсэн дээрх дэмжлэгийн хүрээнд газар тариалангийн салбарт бий болсон үйлдвэрлэлийн хэмжээ, ажлын байр, татварын орлого, дотоодын хүнсний хангамж, импорт орлуулалт, экспорт болон боловсруулах үйлдвэрлэлд үзүүлсэн бодит үр дүнг тоон үзүүлэлтээр мэдээлж, дэмжлэгийн үр нөлөөг хэрхэн үнэлж байгаа талаар;

2026000191

5.Үр, тариалалт, хураалт, хадгалалт, агуулах, тээвэрлэлт, боловсруулалт , борлуулалт хүртэлх газар тариалангийн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний өнөөгийн хүчин чадал, тулгамдсан асуудал, ашиглалтын түвшин болон төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;

6.Цаашид газар тариалангийн газрыг үр ашигтай ашиглах, зориулалтын дагуу ашиглагдаагүй газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, төрийн дэмжлэгийг үйлдвэрлэлийн бодит үр дүнтэй уялдуулах, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл болон хүнсний хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бодлого, арга хэмжээ, эрх зүйн шинэчлэлийн талаар.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Д.БАТБАЯР

2026000191